



Б Н М А У

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

19 01 оны 18 сарын 19

№ 355

Улаанбаатар
хот

Хотын Соёлын төв байгуулах
тухай.

БНМАУ-ын Засгийн газрын 1991 оны 159-р тогтоолын дагуу соёл, урлагийн байгууллагууд, нийслэлийн зарим уран бүтээлчдээс гаргаж байгаа санал хүсэлтийг үндэслэн Ахмад залуу үеийнхний дунд зохиох урлаг, сурталчилгаа, соёл олон түмний ажлын цар хүрээг өргөжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ НЬ:

1. Улаанбаатар хотын Ахмадын соёлын төвийг 1991 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болгон татан буулгаж түүний материаллаг бааз, үндсэн хөрөнгийг түшиглүүлэн Улаанбаатар хотын Соёлын төвийг шинээр байгуулж хотын соёл, олон түмний ажлын хэлтсийн мэдэлд харьяалуулан ажиллуулсугай.

2. Ахмадын Соёлын төвийн үндсэн хөрөнгө, техник хэрэгсэл, эд материалыг соёл, олон түмний ажлын хэлтэст балансаас балансад шилжүүлэн өгөхийг Хотын Ахмадын хороо / н. Дашдаваа /-д үүрэг болгосугай.

3. Хотын Соёлын төвийн холбогдох зардлыг төсөв төлөвлөгөөнд тусган санхүүжүүлэхийг Хотын Ардын Хурлын Гүйцэтгэх Захиргааны нийгэм, эдийн засгийн бодлогын зөвлөл, санхүүгийн газарт даалгасугай.

4. Соёл, олон түмний ажлын хэлтэс / н. Сарантуяа /-д даалгах нь:

а. Хотын Соёлын төвийн бүтэц, зохион байгуулалт

ажлын үндсэн чиглэлийг тодорхойлон тогтоож мэргэжилтэй боловсон хүчнээр хангаж, үйл ажиллагааг нь бэхжүүлж ажилласугай.

б. Хотын Ахмадын байгууллагаас тус төв дээр зохиох ажлыг бүх талаар дэмжиж, ахмад уран бүтээлчдийн санаачлан байгуулсан чуулга, хамтлагуудын тоглолт бэлтгэл сургуулилалтанд мэргэжлийн туслалцаа үзүүлж хамтран ажиллаж, Хотын Ахмадын Хорооноос зохиох ажилд үнэ төлбөргүй үйлчилж байсугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх Захиргааны 1991 оны 236 дугаар тогтоолын хавсралтын "Б" хэсгийн I дүгээр заалтыг хүчингүй болсонд тооцсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА

Л. ЭНЭБИШ.

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

Ц.БОЛДСАЙХАН